

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-12

---

1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	3-11
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай”/	12

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны 06 дугаар  
сарын 13-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 13 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Баярсайхан, Л.Энх-Амгалан, Б.Энхбаяр.

**Нэг.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, мэргэжилтэн П.Энхманлай, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн Ажлын албаны Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга Д.Чимэдгаваа, Сургалт, судалгаа мэдээллийн нэгдсэн сангийн газрын дарга А.Амармэнд, Авлигатай тэмцэх газрын Тамгын газрын дарга З.Баасаням, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Б.Бейсен, Х.Баделхан, Н.Энхболд, Ш.Адъяаа, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Баттөмөр хариулж, тайлбар хийв.

**Б.Баттөмөр:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 40 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 53 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон  
“Үндсэн хууль” танхим  
10 цаг 13 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023  
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ 06 ДУГААР  
САРЫН 13-НЫ ӨДӨР /МЯГМАР  
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Баттөмөр:** Байнгын хорооны гишүүдийн энэ өнөөдрийн амар амгаланг эрж, мэндчилье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 60 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя.

Баттөмөр ирсэн байна. Адъяаа гишүүн ирсэн байна. Баделхан гишүүн ирсэн байна. Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Бейсен гишүүн ирсэн байна. Бямбацогт гишүүн ирсэн байна. Ингээд Л.Энх-Амгалан гишүүн ирэх хэрэгтэй. Б.Энхбаяр гишүүн алга байна. Н.Энхболд гишүүн алга байна. Энэ гишүүд Энхболд гишүүн, Энхбаяр гишүүн хуралдаа ирье. Энх-Амгалан гишүүн, Баярсайхан 2-ын хувьд бол чөлөөтэй байгаа.

Хэлэлцэх асуудалдаа орно.  
Хэлэлцэх асуудал.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хургуулна.

2 дахь нь бол Байнгын хорооны цаглавар батална.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна.

**Төсвийн тодотголын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан байна. Булгантуяа сайд байна, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Занданбат Монгол Улсын Ерөнхий аудитор, Мөнгөнчимэг Сангийн дэд сайд, Наранчимэг Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Самбууням Аудитын нэгдсэн удирдлагын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэх-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Чимэдсүрэн Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Хишигбаяр Хөдөлмөрийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого төлөвлөлтийн газрын дарга Алимаа, Хөдөлмөрийн хамгааллын яамны газрын дарга Баярмаа, Хөдөлмөрийн хамгааллын яамны мөн Гэр бүл, бодлого хэрэгжүүлэлтийн газрын дарга, Одонтуяа Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Дэлгэржаргал Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Төгөлдөр Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Цолмон Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Энхманлай Төсвийн зарлагын хэлтсийн

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мэргэжилтэн, Цолмон Төсвийн нэгтгэлийн хэлтсийн мэргэжилтэн, ТАЗ, АТГ-аас Баатарзориг дарга Төрийн албаны зөвлөлийн дарга, Чимэдгаваа Төрийн албаны зөвлөлийн Аудитын газрын дарга, Амармэнд Сургалт, судалгааны мэдээллийн нэгдсэн сангийн дарга, Авлигатай тэмцэх газрын Тамгын дарга Баасанням байна. Дуламсүрэн Авлигатай тэмцэх газрын Ажлын албаны дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энд ирсэн байна.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдыг урьж байна.

**Б.Жавхлан:** Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикийн хурцадмал байдлаас улбаатай инфляцын дарамт, урд хөршид тогтоосон хөл хорио, улс орнуудын төв банкнуудын хэрэгжүүлсэн мөнгөний эрс хатуу бодлого зэрэг нь манай улсын эдийн засагт томоохон сорилт болж байна. Тэгсэн хэдий ч Засгийн газраас экспортыг эрчимжүүлж, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, эдийн засгийг сэргээхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай авсны үр дүнд 22 оны 1 дүгээр улиралд 3,9 хувиар агшаад байсан эдийн засаг 23 оны 1 дүгээр улиралд 7,9 хувиар өсөж, 2,4 тэрбум долларт хүрч, унаад байсан гадаад валютын албан нөөц энэ оны эхний 5 сарын байдлаар 3,8 тэрбум долларт хүрч сайжирлаа. Эдгээр

эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд эерэг өөрчлөлтүүд гарч эхэлсэн боловч гадаад хүчин зүйлийн нөлөөгөөр сүүлийн 20 сар дараалан Монгол Улсын инфляцад 2 оронтой тоонд байж, иргэдийн бодит орлогод нөлөөлж байгаа тул ард иргэдийн орлого амьжиргааг дэмжих зайлиггүй шаардлагыг бий болгож байна.

Дээр дурдсан эдийн засаг, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын Засгийн газраас хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн албан хаагчдын орлогын баталгааг сайжруулах, иргэдийн амьдрах орчныг дээшлүүлэх, хотын түгжрэлийг бууруулах чиглэлээр дараах багц арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгалаа. Үүнд:

1 дүгээрт, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан өрхийн хүүхдэд олгохын зэрэгцээ энэ оны 01 дүгээр сараас хүүхдийн мөнгөнөөс хасагдсан өрхийн хүүхдэд хүсэлт гаргасан тохиолдолд нөхөж олгоно.

Нийгмийн даатгалын тэтгэврийн зөрөөний асуудлыг цалингийн суурь итгэлцүүрийг шинэчлэх замаар нэг мөр шийдвэрлэнэ. Үүн дээр нэмээд үнийн өсөлттэй уялдуулж тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцлоо. Тэтгэврийн зөрөөг арилгах, цалингийн итгэлцүүрийг шинэчилснээр 164,6 мянган хүний тэтгэвэр нэмэгдэх бол тэтгэврийн зөрөөг арилгасны дараах сууриас тэтгэврийн хэмжээг 10 хувиар нэмэгдүүлснээр нийт тэтгэвэр авагч буюу 496,3 мянган хүн хамрагдаж, нийтдээ 394,6 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг мөн үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэхээр тооцлоо. Нийгмийн даатгалын тэтгэвэр авах эрх үүсээгүй хүнд олгох халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж тус бүр 288

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

мянган төгрөг байгааг нэгэн адил 325 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлэх. Түүнчлэн нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж 84,5 мянган төгрөг байгааг 275 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлэ, мөн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмж 123,1 мянган төгрөг байгааг 275 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлнэ. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 144,3 мянган хүн хамрагдах бөгөөд 89,8 тэрбум төгрөг нэмж зарцуулахаар байна.

2 дугаарт, төрийн албаны цалингийн шинэчлэлийн хүрээнд хэт олон сүлжээ шатлал бүхий харилцан адилгүй тэгш бус үнэлэмжтэй төрийн албаны цалингийн тогтолцоог нэгтгэх замаар адил үнэлэмж бүхий ажил хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагчийн цалин ижил байх зарчимд нийцүүлээ.

Төрийн албан хаагчдын цалинг 07 дугаар сарын 01-нээс нэмэхэд нийт 994,6 тэрбум төгрөгийг зарцуулахаар байна.

3 дугаарт, нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн хүрэлцээг нэмэгдүүлэх, авто замын сүлжээг өргөтгөх, зам, замын байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг нийслэлийн үнэт цаас гаргах замаар санхүүжүүлж, төсөв хооронд зохицуулалт хийж шийдвэрлэнэ. Төсвийн тодотголоор шийдвэрлэх дээрх багц арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг төсвийн тэнцвэржүүлсэн орлогын давалт, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон төсвийн алдагдлын орон зайнаас санхүүжүүлэхэд төлөвлөж байна. Төсвийн тодотголын арга хэмжээний үр дүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 1 их наяд 732,3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 20,8 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага мөн 1 их наяд 896,1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 22,4 их наяд төгрөг, нийт нэгдсэн төсвийн нийт алдагдлын хэмжээ 1,6 их наяд төгрөг буюу анх батлагдсан

Дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6 хувьтай барьж байхаар төлөвлөлөө.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баттөмөр:** Жавхлан сайдад баярлалаа.

Одоо 2023 оны төсвийн тодотголын төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат танилцуулна. 2 дугаар микрофон.

**Д.Занданбат:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20 их наяд 781,9 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 34,5%, нийт зарлагын хэмжээг 22 их наяд 371,4 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 37,2%, төсвийн алдагдлыг 1 их наяд 589,5 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2,6% байхаар төлөвлөжээ.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Засгийн газраас өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн тодотголд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхий захирагчдын төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Төрийн албаны зөвлөлийн дарга 2023 оны тодотголын төсөлд 3,9 тэрбум төгрөгөөр, АТГ 33,2 тэрбум төгрөгөөр төсөвлөж орж ирсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын төсөв 0,3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд төрийн албан хаагчийн цалин хөлсний системийг шинэчлэн цалинг нэмэгдүүлэн тогтоосонтой холбоотой байна.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Баттөмөр:** Занданбат даргад баярлалаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотголын төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх танилцуулгыг Улсын Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Хууль санаачлагч болон Байнгын хорооны эрхлэх ёсны хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуух асуулттай гишүүн байна уу. Кнопоо дар. Адьшаа гишүүнийг нэмчихье. Төгсгөлд нь би бас үг хэлнэ.

Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Би 2 асуулт асуух гэсэн юм.

1 дүгээрт, Сангийн сайдаас 2 дугаарт, энэ аудитын даргаас. Энэ

хүүхдийн мөнгөний хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгоно гээд тэгж байна л даа, Сангийн сайд аа. Ер нь боломж байвал ялгаварлан гадуурхахгүйгээр ер нь хүүхэд бүрд олгочихвол яасан юм? Одоо энэ зудтай, ер нь юмны инфляцын байдал, юмны өсөлттэй холбоотой ер нь сая хөдөө явж байхад ер нь байдал хүнд байгаа юм байна, ер нь. 1 дүгээрт боломж байвал уг нь та боломжтой юм ярьж байна. Тэрийг олгочихвол яасан юм, ер нь 1 дүгээрт.

2 дугаарт, энэ Аудитын газрын даргаас сая хөдөө явж байхад ихэнх хүүхдүүд тэр мөнгөний юугаа авч чадаагүй байна ерөөсөө, халамж үйлчилгээний газруудаар олгохгүй байна гээд чирэгдэл ихтэй. Тэгэхээр энэ аймгуудын Халамж үйлчилгээний газар, сумдын энэ олголтын асуудлыг шалгасан уу, энэ зөрчил байна уу, энэ та зөрчилгүй гээд яриад байх юм. Уг нь сая бид хөдөө энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт гээд хөдөө явж байхад энэ бүх улсууд мөнгө авч чадахгүй байна, чирэгдэл ихтэй гээд ярьж байна. Энэ талаар шалгалт хийсэн юм байна уу?

**Б.Баттөмөр:** Жавхлан гишүүн, Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүдийнхээ өглөөний мэнд ээ. Бейсен гишүүний асуултад хариулъя. Би тантай санал нийлж байна аа. Энэ зүгээр зохион байгуулалтын л асуудал юм байгаа юм. Хүүхэд бүрд боломж өгч байна л гэсэн үг, эндээс зүгээр, харин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан маань нэг ийм сонголт хийх боломжийг өгч байгаа. Тэр нь хүүхдийн мөнгөө шууд өөр дээрээ авалгүйгээр хүүхдийн төлөө фондод гэр бүлийнхээ өмнөөс үр хүүхдүүдийнхээ өмнөөс тийшээ хандивлах тийм боломж сонголтыг л өгч байгаа юм гэсэн үг. Тэгээд нөгөө хэрвээ тийм хүсэлт гараагүй л бол бүх хүүхдэд очихоор ийм зохион байгуулалт хийгдэж байгаа. Тэгэхээр тэнд ямар нэг ялгаварлан гадуурхах ч юм уу, тэгж хүндээр тодорхойлж яах бол



2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

сонголт хийх шаардлага байхгүй ээ л гэж хэлье дээ. Тийм. Баярлалаа.

**Б.Баттөмөр:** Өөр нэмж хариулах юм уу? Жавхлан гишүүн сайд хариулчихлаа. Одоо нэмж юу, яагаа вэ, аудитаас юу. Занданбат 2 номерын микрофон өгье.

**Д.Занданбат:** Бейсен гишүүний асуултад хариулъя. 2022 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг сая аудит хийж дуусаад, сая Засгийн газарт, Их Хуралд өгсөн байгаа. Таны яриад байгаа тэр хүүхдийн мөнгөний асуудал бол энэ санхүүгийн аудитын тайлангаар нэг бүрчлэн бас нэг нарийн бол гарч ирэхгүй байх. Зүгээр Баян-Өлгий аймгийн халамжийн газарт Баян-Өлгий аймгийн Аудитын газар нь зөвхөн санхүүгийнх нь баланс дээр нь бол аудит хийсэн дүн бол энэ Засгийн газрын нэгдсэн тайлангаар гарч ирнэ.

Бид нар маргааш Төсвийн байнгын хороонд 2024 онд хийх аудитынхаа сэдвийг батлуулах хүсэлтийг гаргачихсан байгаа. Хэрвээ та сүүлд яг Баян-Өлгий аймгийн аудит юу Халамжийн газар дээр тэр хүүхдийн мөнгийг хэрхэн олгосон тал дээр тусгайлан гүйцэтгэл-нийцлийн санхүүгийн биш гүйцэтгэл-нийцлийн аудитыг хийлгэхээр хүсэлтэй байгаа бол бас тэр үед нь саналаа хийгээд ингээд явах юм бол бас хийгээд явчихна. Яг таны яриад байгаа тэр төсвийн хүүхдийн мөнгөний гүйцэтгэл бүрэн дүүрэн байна уу гэдэг бол санхүүгийн аудитаар гарч ирдэггүй, тэр нийцэл гэдэг аудитаараа гарч ирдэг. Тэр нь бол тусгайлан сэдэв баталдаг ийм хуулийн зохицуулалттай байгаа.

Баян-Өлгийн аудитын газраас тусгайлан тэр халамжийн газар дээр хийгдсэн аудит тэр балансынх нь тал дээр бол би бас мэдээллийг аваад танд бас хүргүүлье.

**Б.Баттөмөр:** Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** Энэ асууж байгаа маань уг нь тэр санхүүгийн юугаар танилцуулах биш ер нь аудитын байгууллага аймгуудын, тэрийг шалгаж авбал төрийн үйлчилгээ энэ төрийн ажил сайн явах байх гэж бодож байна л даа. Наад зах нь татварыг авч үзье, ер нь. Татварыг нэг НӨАТ-ын юу явуулаагүй байхад 1000500-гаар торгодог. Хотын хаана ч гэсэн та асууж болно. Гэтэл сая 500-гаар торгуулахгүйн тулд байцаагч нарт нэг 300-400 мянган төгрөгийн хахууль өгөөд тэгээд хаадаг ийм асуудал байгаа. Тэгээд тэгэнгүүт нь дансаа нээгээд нөгөө юугаа нээчихдэг ийм асуудал гараад байгаа, гомдол ч ирчихсэн байгаа. Тийм учраас энэ санхүүгийн талын асуудал дээр ингээд тэр халамж үйлчилгээ байна. Татвар яагаад, энэ шалгаад шалгалтын дүнгээр мэдэгдэхгүй бол энэ төр хавтгайрсан, авлига маягийн юманд орчихоод байна шүү дээ, ер нь. Бодит мэдээлэл өг гэвэл өгч болж байна.

**Б.Баттөмөр:** Занданбат дарга тодруулчихъя. 2 номерын микрофон өгье.

**Д.Занданбат:** Бейсен гишүүн ээ, бас нэг мэдээлэл танд өгчихье. Одоо бид нар 6 сарын 19-нд Ховд, Баян-Өлгийн татварын газар дээр дотоод хяналтаараа шалгалт хийж байгаа. Түүн дээр тусгайлан бас нэг асуудлын чиглэл өгөөд тэгээд тэндээс 7, 14 хоногийн дараа мэдээллүүд нь гараад ирнэ. Түүнтэй бас нийцүүлээд, бас эргээд танд Баян-Өлгий дээр тэр халамжийн асуудал дээр ямархуу нөхцөл байдлууд байна вэ гэдгийг шуурхай мэдээд ингээд өгье.

Жил болгон санхүүгийн аудитыг бол хуульчилсан Төсвийн хуулийн дагуу хийгдээд тэгээд тэр Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийгээд, ингээд 6 сард нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр Их Хуралд тайлагнадаг шүү дээ.

**Б.Баттөмөр:** Занданбат дарга тэр холбогдох мэдээллүүдийг Бейсен гишүүнд бас өгөөдхөөрэй.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Баделхан гишүүн асуултаа асууя.

**Х.Баделхан:** Баярлалаа. Энэ төсвийн тодотголтой хамт нөгөө хэмнэлтийн хуульд өөрчлөлт орно гэж ярьсан шүү дээ. Энэ төрийн байгууллагуудын ажиллах нөхцөлийг бас хангах талаар анхаарч тэр хэмнэлтийн хуулийн зарим заалтад өөрчлөлт оруулъя гэж. Яг энэ чиглэлээр өөрчлөлт ороод энэ одоо бид нар өнөөдөр ярьж байгаа энэ ТАЗ байна. АТГ, Ерөнхий аудиторын юун дээр өөрчлөлт орсон. Хэмнэлтийн хууль өөрчлөөд орсон өөрчлөлт байна уу? Нэг дэх асуулт.

2 дахь нь, энэ АТГ, Ерөнхий аудиторын төсвийг бидэнд тараасан материалыг үзэхэд тухайлбал бараа үйлчилгээний зардал бол АТГ гээд буурчихсан байна. Харин эсрэгээрээ бол Ерөнхий аудитор дээр бол нэмэгдсэн 2,2 тэрбум төгрөгөөр. Энэ дээр бас нэг тайлбар авъя гэж бодож байгаа. Баярлалаа.

**Б.Баттөмөр:** Хэн хариулах юм? 1 номерын микрофон. Сангийн яам. 1 номерын микрофон өгье, ажлын хэсгийн. Өнөөдөр энэ төхөөрөмж зоонон муу ажиллаад байна. Яагаад ингээд.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Баделхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ удаагийн тодотголоор зарлага нэмэгдүүлэх асуудал дээр бол зөвхөн 2, 3 төрлийн үндсэндээ зарлага нийтлэг нэмэгдэж байгаа. Энэ нь цалин нэмэгдүүлэх асуудал бол нийт төрийн албан хаагчдын хувьд нэмэгдэж байгаа.

Дээрээс нь халамж, тэтгэврийн асуудал байгаад байгаа юм.

Аудитын хувьд бидний нөгөө цалин нэмэгдүүлж байгаа бодлого маань юу вэ гэхээр сая төгрөгөөс доошоо цалинтай, үндсэн мэргэжлийн энэ цалингууд дээр бид нар жаахан дээш нь татах ийм

бодлого тавьж нэмэгдүүлсэн байгаа. Үүнтэй холбоотойгоор нэмэгдсэн. АТГ-ийн хувьд цалин нь өөрөө энэ шатлалаас дээшээ гарчихсан, дээд шатлал нь бас тэрнээсээ өндөр байгаа учраас тэр дээд талын өндөр цалинтай хэсгээ энэ удаадаа бол орхиод доод хэсгийн цалингаа дээш нь татах ийм тэр тохиргоонд ороогүй гэж хэлж болно.

Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр хэд хэдэн заалтууд бид оруулж ирж байгаа. Энэ дээр 1 дүгээрт, багийн даргатай холбоотой автомашинтай холбоотой асуудал орж ирсэн. Багийн дарга нар ихэвчлэн мотоцикл албан унаандаа бол хэрэглэдэг. Үүнтэй холбоотойгоор үүнийг эрхийг нь нээж өгөхгүй бол шатахууны зардал нь давхар сум дээрээ хасагдаад явчихдаг учраас өөрийн хувийн машинтай ч бай, мотоциклтой ч бай үүнийгээ унаж чадахгүй байгаад байгаа ийм асуудал орж ирсэн байгаа.

Мөн мэргэжлийн зарим байгууллагууд дээр үндсэн үйл ажиллагаатай нь холбоотой зардлууд бол хэмнэлтийн хуулиар бол нэлээд хатуу зохицуулалттай. Энэ нь дараа нь аудит дээр зөрчил болоод байгаа асуудал байсан. Жишээ болгож хэлэхэд номын сангийн хувьд ном худалдан авах зардал маань өөрөө хэмнэлтийн хуульд хамаарахаар орчихсон байгаад байсан. Үүнийг яг өөрөө мэргэжлийн байгууллага нь учраас энэ асуудал дээр оруулж ирсэн байгаа.

Мөн дээрээс нь Хөдөлмөр аюулгүй байдлын хувцас хэрэглэл гэж байдаг. Бээлий, каск, эрүүл мэндийн байгууллагуудын хувьд мөн түлхүү хэрэглэдэг ийм хэрэгслүүд байдаг. Эдгээр асуудлууд дээр бол бас хэмнэлтийн хуулиар нэлээд хатуу зохицуулалттай байгааг оруулж ирсэн, хөндөж оруулж ирсэн ийм байгаа.

**Б.Баттөмөр:** Асуулт асууж хариулт. Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт энэ өдрийн мэнд хүргэе. Энэ зарим байгууллагуудынх нь танилцуулгууд нь задаргаатай, зарим нь задаргаагүй дүнгээрээ ороод ирсэн байх юм. Энэ задаргаатай нь өгч болоогүй юм уу гэсэн нэг асуулт байна.

2-т, энэ удаагийн төсвийн тодотголоор үндсэндээ цалин, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгөтэй холбоотой зүйлүүд дээр л Жавхлан сайд аа, өөрчлөлт оруулах ийм зарчим барьсан. Бүлэг дээр ч тэгж ярьсан, Их Хурал дээр ч тэгж ойлгогдсон. Тэгээд энэ зарим байгууллагуудын ирсэн задаргааг харахаар энэ дотор нь нөгөө эд хогшил, урсгал зардал, томилолт, зочных, гээд нэмэгдсэн зүйлүүд байх юм. Яах вэ, нийт дүнгээрээ төсвөө дотроо зохицуулалт хийгээд нэг хэсгээс нь хасаад, дотроо багтаагаад батлагдсан төлөвлөгөөгөө нөгөө төлөвлөгөөнөөсөө нөгөөх рүү нь шилжүүлээд, ингээд дүнгээ бариад явсныг бол ойлгож байна. Дүнгээсээ илүү гарчихсан юмнууд нөгөө бид нарын анхнаасаа тохирсон тэр зарчмуудтай хэр нийцэж байгаа юм бэ. Бусад зардлууд, эд хогшил ингээж яривал бүх л байгууллагууд бас л ийм юмнууд оруулж ирнэ шүү дээ.

Дахиад хэлэхэд дүн дотроо багтаагаад, өөрснөө зохицуулаад ирснийг нь ойлгож байна. Зарим байгууллагуудын юмнууд бол ялангуяа тэр задаргаа нь ирээгүй байгууллагууд дээр нэлээд их хэмжээгээр нэмэгдчихсэн юмнууд байгааг, зөвхөн цалин тэтгэвэр тэтгэмжтэйгээ холбоотой тийм байна уу? Өөр юм орж ирээд тэгсэн байна уу? Үгүй ээ, энэ л байж л байна шүү дээ. Бид нарт ирсэн материал.

Дээр нь энэ Их Хурлын Тамгын газар дээр нөгөө Хууль зүйн үндэсний хүрээлэнг аваад зардал нь нэмэгдсэн, үүнийг ойлгож байна. Нөгөө талдаа хасагдсан байлгүй дээ бодвол тийм ээ. Түүнийгээ бас Тамгын газрынхан нэг тайлбар хэлчихвэл сайн байна. Тэгэхгүй бол Тамгын газар өөрөө уриалаад л бусад

зардлаа нэмсэн юм шиг харагдах вий дээ. Их Хурал руу янз бүрээр зардал чирэгдлээ нэмэгдүүлсэн гэсэн асуудал гарах вий. Ийм зүйлүүд дээр тайлбар өгнө үү. Над дээр хэлсэн юман дээр энд байна даа, сайд аа.

**Б.Баттөмөр:** Жавхлан сайд хариулъя. Тэр Санжаадорж эхлээд хариулъя. Сангийн яамны газрын дарга Санжаадорж 1 номерын микрофон.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Энхболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Улсын Их Хурал дээр хэрвээ эд хогшил, тавилга, урсгал засвар гэх мэт зардлууд нэмэгдэж байгаа бол нөгөө шинэ байгууллага нэмэгдэн ороод ирж байгаа. Тэр маань өөрөө суурь нь 0 байсан гэсэн үг. Нөгөө талдаа Хууль зүйн яаман дээр 07 дугаар сарын 01-нээс эхлээд баланс нь хаагдахаар бид нар тэрийг бол тавьчихаж байгаа. Тэгэхээр нөгөө талдаа хасагдаад явчхаж байгаа гэсэн тийм юм байгаа.

Бусад байгууллагуудын хувьд Улсын Их Хурлын ажлын албанаас яг ямар хүснэгт гаргаж өгснийг бол би нөгөө хараагүй учраас мэдэхгүй байна. Зүгээр оны эхэнтэй харьцуулсан бол он эхэлснээс хойш хуваарийн өөрчлөлтүүд бол төсвийн ерөнхийлөн захирагч нар хийх хэрэгтэй байдаг. Тэр үнэндээ өөрчлөлт гарсан байхыг бол үгүйсгэхгүй. Яг түрүүний таны хэлдгээр өөрөөр хэлбэл батлагдсан төсөв дотроо бол хуваарийн өөрчлөлттэй бага зэргийн өөрчлөлт орсон байхыг бол үгүйсгэхгүй. Бусдаар төсвийн тодотголоор бид нар 5 сарын суурин дээр ямар нэгэн байдлаар бол зөвхөн цалингийн зардал нэмсэн байгаа. Халамжийн зардал нэмсэн байгаа. Хүүхдийн мөнгөний зардал нэмсэн байгаа.

Эд хогшил, тавилга, урсгал засвар гэх мэт бусад бүх эдийн засгийн ангилал дээр бол 1 төгрөг ч нэмээгүйгээр бол орж ирсэн байгаа.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Б.Баттөмөр:** Тэр Их Хурлын Тамгын газрын улсууд хаана байгаа юм, тэр үзээдхээч, тэр юу. Энэ одоо төсвийн тодотгол гээд л бид чинь маш их удаан ярьж байгаа шүү дээ. Тэгэхэд өнөөдөр ингээд энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын юу гээд энэ материалуудыг өнөө өглөө өгч байгаа байхгүй юу. Хүн унших, танилцах энэ чинь юун, танилцах ёстой шүү дээ, энэ чинь. Үүнийг тэгээд тодруулж бариад Жавхлан сайд аа, тийм. Үүнийг буруу зөрүү юм тараагдаад, буруу ойлголттой ингээд яваад байх шиг байна шүү дээ. Сайдын сая хэлж байгаагаар бол тийм юм тараагдаагүй гэж байна, тийм.

Аль юм Энхболд гишүүн ээ, аль юм, аль юм. Энэ тараагдсан байна шүү дээ.

Адъяаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адъяаа:** Төсвийн тодотголын асуудал энэ цалин хөлстэй холбоотой, эдийн засаг өссөнтэй холбоотойгоор өнөөдөр төсвийн тодотгол хийж байгаа тухай манай Засгийн газар ингээд ярьж байгаа. Тэгээд улс орны эдийн засаг сайжирч, төсөв бас алдагдалгүй байгаа ийм судалгаа байгаа нь сайн хэрэг ээ гэж ойлгож байна.

Энэ Улсын Их Хурал ч юм уу, энэ Засгийн газрын энэ уялдаа холбоо чинь юу болоод байна аа. Энэ буруу материал орж ирсэн ч гэх шиг. Энэ байхгүй гээд ийм юмыг ингэж хариуцлагагүй юм яримааргүй байна. Бид нар өнөөдөр энэ төсвийн тодотголыг Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын энэ Байнгын хороо хэлэлцэж байгаа. Тэгэхээр энэ мэдээллүүд чинь ингээд зөрөөтэй явагдаад байна. Энэ дээр хэн нь тайлбар өгөх юм.

Дээр нь энэ төсвийн ерөнхийлөн захирагч нарын цалин хөлснөөс бусад урсгал зардлууд энэ өссөн л юмнууд харагдаад байх юм. Тэгээд энэ талаар нэг тайлбар авъя.

Дээр нь энэ хэмнэлтийн хууль гээд бид чинь жилийн өмнө л бөөн юм ярьж л бүр баларлаа гээд л хэмнэлтийн хууль гэдэг юм гаргаад л ингээд л нэг яриад л байсан. Эргээд энэ хэмнэлтийн хууль чинь хэрэггүй боллоо. Одоо хэмнэх шаардлагагүй юм байна, энэ урсгал зардлаа бусад юмаа нэмье гэж байгаа юм уу, ер нь ямар учиртай юм. Яагаад энэ хэмнэлтийн хуулиа эргээд ингэж хүчингүй болгож, зарим зүйлийг нь ингэж хэмнэх шаардлагагүй болгосон ийм асуудлыг өнөөдөр ярьж эхэлж байна. Энэ тал дээр нэг тайлбар авъя.

Ер нь энэ цалин, тэтгэврийн асуудал, энэ хүмүүсийн амьжиргааны асуудал нэмэх ёстой. Энэ дээр бол Засгийн газар бас тодорхой ийм дүгнэлт хийж, эдийн засаг нэмэх өсөлттэй холбогдуулж цалин, тэтгэвэр бусад асуудлыг шийдэж байгаа гэж ойлгож байгаа. Гэтэл өнөөдөр тэр хүмүүсийн амьжиргааны асуудал, наад захын амьжиргааны асуудал, түүнчлэн энэ ажлын байр, бизнесийг дэмжих талаар энэ ер нь ямар бодлого энд явагдах вэ. Одоо цалин, тэтгэвэр нэмлээ гээд л үүнтэй уялдаж тэр инфляц бусад юмны үнийн хөөрөгдлийг багасгах, хязгаарлах талаар ямар зохицуулалт хийсэн бэ? Үүнээс сэргийлэх ямар хууль, эрх зүйн хувьд, бодлогын хувьд ямар арга хэмжээ авч байгаа талаар бас нэг тайлбар авъя гэж бодож байна.

**Б.Баттөмөр:** Жавхлан сайд хариулах уу. Жавхлан сайд хариулъя.

**Б.Жавхлан:** Адъяаа гишүүний асуултад хариулъя. Энэ удаа бүтэн жилийн төсөв биш 23 оны төсөв дээр тодотгол хийж байгаа. Тийм, тодотголоор бид нар бүх зүйлийг хамарч чадахгүй. Энэ удаагийн тодотголоор зөвхөн иргэдийнхээ бодит орлого, хувь хүний өрхийн орлогыг дэмжсэн ийм төсвийн тодотгол хийж байгаа. Цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгө, зорилтот халамжийн тэтгэмж, мөн нийслэлийн түгжэрэлийг ч орхиогүй. Яг ийм 5 асуудал

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

дээр бид төвлөрч нийтдээ 1 их наяд 896,4 тэрбум төгрөгийн тодотгол хийж байгаа. Бодит секторыг бизнесийн орчныг дэмжих маань 23 оны бүтэн төсөв дээр болон шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын төлөвлөгөө болон салбар яамдын бүхий л бодлогын асуудлуудад тусгаад ингээд ажлууд маань явж байгаа. Тийм.

**Б.Баттөмөр:** Ингээд энэ төсвийн тодотгол бол хамгийн анх энэ Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороогоор өнөөдөр эхэлж байгаа юм. Ингээд цаашдаа үргэлжлээд ингээд 12 цагаас Эдийн засгийн байнгын хороо, 2 цагаас Аюулгүй байдлын байнгын хороо гээд ингээд үргэлжлээд цаашаа яг явах юм. Тэгээд энэ тоонууд дээр бас учир байна шүү, Жавхлан сайд аа. Үүнийг энэ холбогдох улсууд нь бас үзээрэй. Энэ дотор танилцуулагдахгүй тоонууд хүртэл явж байна шүү, миний ойлгож байгаагаар. Тийм ээ, тэр Тусгай хяналтын дэд хороон дээр яригдах баригдах юмнууд хүртэл энд ингээд орчихсон. Үүнийгээ энэ Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэхээс өмнө одоо 12 цагаас өмнө Санжаадорж оо, та нар ингээд сайхан янзалчих нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Би ганцхан зүйл хэлье. Цалин хөлс нэмж болно, тэтгэвэр тэтгэмж нэмж болно. Тэгэхдээ энэ бол инфляцад нөлөөлөх ёсгүй шүү. Ханишийг нь тэр тогтвортой байдалд нөлөөлөхгүй байх ийм саналыг би хэлж байгаа шүү. Үүнийг бол протоколд тусгаад цаашаагаа яригдах ёстой ийм саналыг хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Ингээд зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Зарчмын зөрөөтэй санал биш ээ. Зүгээр Байнгын хорооныхоо санал, дүгнэлтэд яг ийм хүрээнд л төсвийн тодотгол хэлэлцэхийг дэмжлээ

гэдэг юм уу, баталлаа гэдэг юм уу нөгөө цалин, тэтгэвэр, тэтгэмж яг саяын тийм 5 зүйлийг нь дурдаад санал, дүгнэлтдээ бас биччихсэн нь зөв болов уу л гэж бодож байна. Байнгын хорооны. Түүнээс хэтрүүлэхгүй өөр юман дээр байхгүй шүү гэсэн утгаар. Яах вэ тэр дотроо юмаа гүйлгэх энэ тэр нь бол тэртээ тэргүй ойлгомжтой заавал нэг их яриад байх шаардлагагүй байх, тийм ээ, тийм.

**Б.Баттөмөр:** Дотор гүйлгэх юмыг энд оруулж ирж ирэх хэрэг байсан юм уу ер нь. Үүнийгээ сайхан зас аа. Одоо ингээд 12-оос Эдийн засгийн байнгын хороотой шүү дээ, тийм ээ. Үүнээс өмнө ингээд хийе ээ. Сая Энхболд гишүүний саналыг та нар бас үзэж яагаарай. Би бас дэмжиж байна.

Ингээд зарчмын зөрөөтэй санал алга байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг хийсэн талаарх Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баделхан гишүүн Төсвийн байнгын хороонд танилцуулна.

Ингээд өнөөдрийн хэлэлцэх 2 дахь хэлэлцүүлэг төсвийн тодотголттой холбоотой 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Ингээд ажлын хэсэг явж болно.

10.51 цаг

Байнгын хорооны тогтоолын төсөл, цаглаврыг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**2023 оны 6 дугаар сард хэлэлцэх асуудлын тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.**

Цаглавартай холбоотой асуудлаар саналтай гишүүн байна уу? Алга байна.

Энхболд гишүүнд өгье.

**Н.Энхболд:** Хууль дагаж мөрдөх журмын тухай хууль маань ямархуу шатандаа байгаа билээ. Яг одоогийн байдлаар. Бид нар энэ 6 сарын сүүлээр хэлэлцээд батлах юм байна шүү дээ. Дүрэм 2 маань. Хорооны дүрэм, дагаж мөрдөх журмын тухай хууль яг аль шатанд байгаа билээ гэдгийг.

**Б.Баттөмөр:** Ёс зүйн хорооны дүрэм бол ажлын хэсэг ажиллаад нэг 80-аад хувьтай явж байгаа. Ёсчлох асуудал бол ингээд яг хийгдэнэ, ийм байдалтай байгаа.

Ингээд санал хураагаад.

Ер нь дүрэм бэлэн болчихсон байгаа юм, Энхболд гишүүн ээ.

Үүнийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулчихъя.

Өнөөдрийн хурал хэлэлцэх асуудлаа дууслаа.

10.53 цаг

Гишүүд, оролцсон гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**